

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/103/НА-СТА-ТШЗ

Баянхонгор аймаг 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhndl@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Агуулга

2. Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Албан шаардлага.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.18 № 2/27

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА
Б.ГАНЦЭЦЭГ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\alban bichig\3-ШША 2-27-20220218.docx

• 005070752

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31		/төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,748,068.00</u>	<u>4,084,504.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,748,068.00	4,084,504.00
351	Түүхий эд материал	103,000.00	95,860.00
35130	Эм боох материал	103,000.00	95,860.00
354	Хангамжийн материал	1,645,068.00	3,988,644.00
35410	Бичиг хэргийн материал	289,000.00	522,800.00
35420	Аж ахуйн материал	73,750.00	235,490.00
35440	Түлш, шатах тослох материал	655,868.00	2,014,854.00
35470	Бусад хангамжийн материал	626,450.00	1,215,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,761,990.66</u>	<u>29,730,656.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,761,990.66	29,730,656.39
392	Биет хөрөнгө	18,261,990.66	17,230,656.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	16,000,000.00	16,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,947,313.00	40,047,213.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	24,080,708.68	28,860,876.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,716,414.29	10,326,414.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,321,027.95	-4,282,094.14
393	Биет бус хөрөнгө	12,500,000.00	12,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,500,000.00	12,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>32,510,058.66</u>	<u>33,815,160.39</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>32,510,058.66</u>	<u>33,815,160.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	32,510,058.66	33,815,160.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,015,100.00	22,015,100.00
51101	Өмч: - төрийн	22,015,100.00	22,015,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	10,494,958.66	11,800,060.39
51210	Өмнөх үеийн үр дүн	10,494,958.66	10,494,958.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,305,101.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>32,510,058.66</u>	<u>33,815,160.39</u>

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	161,516,648.99	178,907,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,359,348.99	7,655,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,359,348.99	7,655,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,359,348.99	4,485,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,141,000.00	4,485,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,218,348.99	00.00
1200018	Үнэ төлбөргүй авсан хүлээн авсан орлого - үндсэн хөрөнгө	00.00	3,170,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	144,157,300.00	171,251,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,157,300.00	167,823,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,157,300.00	167,823,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,428,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,428,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	156,495,908.80	177,602,198.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,495,908.80	177,602,198.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	155,987,131.24	176,491,949.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,023,644.70	139,765,416.07
210101	Үндсэн цалин	66,112,979.61	83,599,620.89
210102	Нэмэгдэл	43,226,725.97	45,460,340.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,683,939.12	10,705,454.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,946,270.24	4,817,435.56
210201	Тэтгэврийн даатгал	460,878.30	1,503,817.66
210202	Тэтгэмжийн даатгал	54,221.21	183,361.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,375.96	146,689.29
210204	Ажилгүйдлийн даатгал	10,843.25	49,347.51
210205	Эрүүл мэндийн даатгал	2,376,951.52	2,934,219.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,091,500.00	5,495,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,550,000.00
210302	Түлш, халаалт	2,682,500.00	2,095,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,859,000.00	1,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,629,113.00	10,341,714.00
210401	Бичиг хэрэг	1,474,100.00	1,674,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,157,113.00	6,241,014.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,067,700.00	1,292,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,900.00	73,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	856,300.00	1,061,000.00
2105	Нормативт зардал	6,003,690.00	6,037,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,204,000.00	5,058,240.00
210502	Хоол, хүнс	1,799,690.00	979,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,110,625.00	343,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	346,500.00	343,500.00
210604	Урсгал засвар	764,125.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,228,600.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,228,600.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,456,292.50	1,949,410.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,038,662.50	1,717,910.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,700.00	48,500.00

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,892.00	33,000.00
210807	Газрын төлбөр	50,038.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,497,395.80	5,741,234.27
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,497,395.80	5,741,234.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	508,777.56	1,110,248.37
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	508,777.56	1,110,248.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	508,777.56	1,110,248.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,020,740.19	1,305,101.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,020,740.19	1,305,101.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	152,298,300.00	175,737,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,141,000.00	4,485,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,141,000.00	4,485,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,141,000.00	4,485,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,141,000.00	4,485,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	144,157,300.00	171,251,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	144,157,300.00	167,823,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	144,157,300.00	167,823,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,428,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,428,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	152,298,300.00	174,197,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,298,300.00	174,197,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,789,522.44	173,087,151.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,023,644.70	139,765,416.07
210101	Үндсэн цалин	66,362,979.61	83,599,620.99
210102	Нэмэгдэл	42,976,725.97	45,460,340.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,683,939.12	10,705,454.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,946,270.24	4,817,435.56
210201	Тэтгэврийн даатгал	469,278.30	1,503,817.66
210202	Тэтгэмжийн даатгал	54,221.21	183,361.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,375.96	146,689.29
210204	Ажилгүйдлийн даатгал	10,843.25	49,347.51
210205	Эрүүл мэндийн даатгал	2,368,551.52	2,934,219.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,091,500.00	5,495,300.00
210302	Түлш, халаалт	2,682,500.00	2,095,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,859,000.00	1,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,412,900.00	11,059,700.00
210401	Бичиг хэрэг	1,661,100.00	1,192,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,645,400.00	7,600,000.00

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,067,700.00	1,292,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,900.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	964,800.00	900,400.00
2105	Нормативт зардал	6,519,490.00	6,679,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,719,800.00	5,700,000.00
210502	Хоол, хүнс	1,799,690.00	979,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,110,825.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	346,700.00	350,000.00
210604	Урсгал засвар	764,125.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,228,600.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	2,228,600.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,456,292.50	2,919,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,038,662.50	2,688,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,700.00	48,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,892.00	33,000.00
210807	Газрын төлбөр	50,038.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	508,777.56	1,110,248.37
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	508,777.56	1,110,248.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	508,777.56	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,539,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,539,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,539,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,539,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,539,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,539,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

од	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,515,100.00	00.00	5,474,218.47	00.00	14,989,318.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,515,100.00	00.00	5,474,218.47	00.00	14,989,318.47

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,020,740.19	00.00	5,020,740.19
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	10,494,958.66	00.00	32,510,058.66
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	10,494,958.66	00.00	32,510,058.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,015,100.00	00.00	10,494,958.66	00.00	32,510,058.66
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,305,101.73	00.00	1,305,101.73
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	11,800,060.39	00.00	33,815,160.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	171,323,800.00	171,199,051.63	124,748.37	99.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,323,800.00	171,199,051.63	124,748.37	99.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,323,800.00	171,199,051.63	124,748.37	99.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,765,500.00	139,765,416.07	83.93	100.00
210101	Үндсэн цалин	83,525,700.00	83,599,620.99	(73,920.99)	100.09
210102	Нэмэгдэл	43,519,800.00	45,460,340.80	(1,940,540.80)	104.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,720,000.00	10,705,454.28	2,014,545.72	84.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,898,300.00	4,817,435.56	80,864.44	98.35
210201	Тэтгэврийн даатгал	1,806,200.00	1,503,817.66	302,382.34	83.26
210202	Тэтгэмжийн даатгал	190,200.00	183,361.60	6,838.40	96.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	152,100.00	146,689.29	5,410.71	96.44
210204	Ажилгүйдлийн даатгал	43,100.00	49,347.51	(6,247.51)	114.50

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	2,706,700.00	2,934,219.50	(227,519.50)	108.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,495,300.00	5,495,300.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	2,095,300.00	2,095,300.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,850,000.00	1,850,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,059,700.00	11,059,700.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	1,192,000.00	1,192,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	7,600,000.00	7,600,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,292,300.00	1,292,300.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,000.00	75,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,400.00	900,400.00	-	100.00
2105	Нормативт зардал	6,700,000.00	6,679,700.00	20,300.00	99.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,700,000.00	5,700,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	1,000,000.00	979,700.00	20,300.00	97.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	350,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	350,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,055,000.00	1,031,500.00	23,500.00	97.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	800,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,000.00	48,500.00	23,500.00	67.36
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00	-	100.00

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	171,323,800.00	171,199,051.63	124,748.37	99.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	167,823,800.00	166,713,551.63	124,748.37	99.34
131001	Улсын төсвөөс санхүүжих	167,823,800.00	166,713,551.63	124,748.37	99.34
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,500,000.00	3,500,000.00	-	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	3,500,000.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	09.00	09.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,428,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,428,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,428,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,428,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,428,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	3428000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,428,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,428,000.00

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 13в/28 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Тус байгууллагын дарга Б.Ганцэцэг нэгдүгээр гарын үсэг, нягтлан бодогч Ч.Батбилэг хоёрдугаар гарын үсгийг зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь эрүү иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тайлант онд 10 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 171,323,8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны зорилго зорилт нь: Байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/87 тоот тушаалаар баталсан "Хууль зүй дотоод хэргийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 177,602.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,664.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,998.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,305.1 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,748.1	4,084.5	2,336.4
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,748.1	4,084.5	2,336.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,762.0	29,730.7	(1,031.3)
Үндсэн хөрөнгө	74,163.7	78,873.6	4,709.9
Хуримтлагдсан элэгдэл	(43,401.7)	(49,143.0)	(5,741.2)
Нийт хөрөнгө	32,510.1	33,815.2	1,305.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	32,510.1	33,815.2	1,305.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	32,510.1	33,815.2	1,305.1

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 4,084.5 мянган төгрөг болж 2,336.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 233.8 мянга, аж ахуйн материал 161.8 мянга, түлш шатах тослох материал 1,359.0 мянга, бусад

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
хангамжийн материал 589.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 78,873.6 мянган төгрөг болж 4,709.9 мянган төгрөгөөр өссөн аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс үнэ төлбөргүй олгосон 3,610.0 мянга төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,099.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил бүртгэсэнтэй холбоотой бөгөөд тайлант онд үндсэн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийгдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг 2021.10.23-ны өдөр хүлээн авч тээврийн хэрэгслийн гэрчилгээг Шүүхийн шинжилгээний албаны нэр дээр 2021.10.19-ны өдөр бүртгүүлсэн боловч Орон нутгийн өмчийн газрын 2021 оны жилийн санхүүгийн тайланд орлого аваагүй байна. Тухайн байгууллага 2021 онд тооллогын бүртгэлээр автомашиныг тоолсон байна.

Өмнөх онд үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр 537,2 мянган төгрөгийг тайлант онд 100 хувь барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 33,815.2 мянган төгрөг болж 1,301.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,301.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 207,058.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 207,058.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 35,734.2 мянган төгрөгөөр бууруулж 175,479.5 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2021 оны 11 сарын тодотголоор 171,323.8 мянган төгрөг болж 4,155.7 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 171,323,8 мянган төгрөгийн төсөв баталснаас 171,323,8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 171,323,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 170,213.6 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 985.5 мянган төгрөг, төсвийн санхүүжилтээс 124.7 мянган төгрөг нийт 1,110.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 дугаартай тушаалаар тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2021 оны жилийн үйл ажиллагааны давсан орлого 3,428.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Баянхонгор аймгийн ШША-ны 2021 оны төсөв баталсан болон тодотгосон шийдвэрийг ирүүлээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 177,602.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 21,106.3 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллага нь 2021 онд нийт 171,251.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 171,251,8 мянган төгрөгийн 149 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	96	0	
	Нийт	27	151	149	0	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн сангаас

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь тусгайлсан чиг үүргийн байгууллага тул Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд хамааралгүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2021.05.01-ны өдрийн 13в/164 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн өмчит хуулийн этгээдэд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэн авч ашиглагч байгууллагатай ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байгаа шалгах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй 1 алдаа зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө.

4.1 Албан шаардлага

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг 2021.10.23-ны өдөр хүлээн авч тээврийн хэрэгслийн гэрчилгээг ШША-ны нэр дээр 2021.10.19-ны өдөр бүртгүүлсэн боловч Орон нутгийн өмчийн газартай ашиглалтын гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”,

Аудитын код **БНА-2022/103/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.05.02-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3-т “ Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч эзэмшигч байгууллага нь шууд данс бүртгэлдээ тусгана” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 40,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг Орон нутгийн өмчийн газарт бүртгүүлж, ашиглалтын гэрээг Орон нутгийн өмчийн газартай байгуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

2021.12.31				/мянган төгрөгөөр/							
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба	1	40,000.0					1	40,000.0		

_____оОо_____

